

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.05.19



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Монгол улсын ДНБ эхний улиралд 2.4% гарч өнгөрсөн оны мөн үеэс саарлаа
- Инфляц 4-р сард 8.6% гарлаа
- ТОП-20 индексийн үнэ 4-р сараас хойш сэргэлээ

### МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.81%	-4.30%	25.47%
MSE A	-0.07%	-4.40%	20.27%
MSE B	0.14%	-4.80%	34.89%
2025/05/12 – 2025/05/16			

### Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
INV	680,978,250.00
KHAN	614,673,715.00
ERDN	378,803,249.00
CUMN	341,142,804.94
GLMT	244,444,331.00
2025/05/12 – 2025/05/16	

### Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HJL	661.30	32.25%
JGV	4,246.00	14.97%
HSX	4,800.00	14.29%
SHV	3,850.00	13.91%
LOT	1,500.00	11.11%
2025/05/12 – 2025/05/16		

2025 он 05-р сарын 19

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

**12,388**

ТОП-20 индекс

**49,962**

MSE A

**18,180**

MSE B

**14,675**



### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

**2.4%**

2024 - I улирал

Инфляц

**8.6%**

2025-04 сар

ГВУН(сая\$)

**5,135.39**

2025-04 сар

Бодлогын

хүү

**12.0%**

ЗГ-ын бондын  
өгөөж

**7.3%**

USD/MNT

**3,572.83**

2025-05-18



## Эдийн засгийн мэдээлэл

### МОНГОЛ УЛСЫН ДНБ ӨСӨЛТ ЭНЭ ОНЫ 1-Р УЛИРАЛД 2.4% ГАРЛАА




Монгол улсын 2025 оны 1-р улирлын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2.4% гарч өнгөрсөн оны мөн үеэс эрс буурлаа. Энэхүү сааралтын шалтгаан нь:

- Түүхий эдийн экспортод мэдрэгдэх сул хандлага,
- Дэлхийн зах зээл дээрх эрэлт буурсан байдал,
- Түүнчлэн мөнгөтэй холбоотой бодлогын тодорхой бус байдал, инфляцийн дарамт зэрэгтэй холбоотой байв.

Энэ нь Монголын эдийн засаг гадаад орчны савалгаа, түүхий эдэд хэт хамааралтай хэвээр байгааг харуулж, макро түвшний эдийн засгийн бодлогын эрсдэл өндөр хэвээр байгааг дахин сануулсан чухал дохио боллоо.

График 1. Эхний улирлын ДНБ өсөлт



2025 оны эхний улиралд ДНБ (оны үнээр, үйлдвэрлэлийн аргаар тооцсон урьдчилсан гүйцэтгэлээр) 19.0 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 их наяд төгрөгөөр (15.2%) өссөн үзүүлэлт болж байна.

Энэхүү өсөлтөд голлон нөлөөлсөн салбарууд:


Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 1.1 их наяд төгрөгөөр (18.6%). Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 1.0 их наяд төгрөгөөр (15.1%) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

### МОНГОЛ УЛСЫН ИНФЛЯЦ 4-Р САРД 8.6% ГАРЛАА



2025 оны 4 дүгээр сарын байдлаар Монгол Улсын инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлт 8.6 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийн 5.7 хувиас 2.9 нэгж хувиар нэмэгдсэн дүнтэй гарлаа. Энэ нь инфляц сүүлийн нэг жилийн хугацаанд огцом хурдацтай нэмэгдсэнийг харуулж байна.

График 2. Инфляцын түвшин



Инфляцын өсөлтөд дотоод болон гадаад хүчин зүйлс голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Импортын бараа, тэр дундаа бензин, түлш зэрэг бүтээгдэхүүнүүд инфляцын өсөлтөд 2.6 нэгж хувь буюу нийт дүнгийн 29.8 хувийг,
- Харин дотоодын бараа, тухайлбал мах, хатуу түлш зэрэг бүтээгдэхүүнүүд 5.0 нэгж хувь буюу 58.1 хувийг тус тус бүрдүүлсэн байна.



## Зах зээлийн мэдээлэл

### ERDN: ЭНЭ ОНЫ 3-Р УЛИРЛААС БАЯНХӨНДИЙН АЛТНЫ ОРДНЫ ОЛБОРЛОЛТ ЭХЭЛНЭ

Төслийн гүйцэтгэл 2025 оны 1-р улирлын байдлаар 92%-д хүрч, 700 гаруй ажилтан талбайд ажиллаж байна. Компанийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал Петер Акерли-гийн мэдээлснээр, уг төсөлд нийт 96 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна.

#### Бэлтгэл ажлын явц:


2025 оны 1-р улиралд уурхайн эхний 10 байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгсөн бол, үлдсэн дэд бүтцүүдийг 2-р улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Үүнд ажилчдын кемп, 240 км цахилгаан дамжуулах агаарын шугам, лаборатори багтана. Боловсруулах үйлдвэр 90%-ийн гүйцэтгэлтэй бөгөөд шугам хоолой, цахилгаан хангамж, туузан дамжуулагч, бутлуур зэрэг тоног төхөөрөмжүүдийг угсарч дуусгах шатандаа явж байна. Уурхайн техник тоног төхөөрөмжүүдийг талбайд нийлүүлж эхэлсэн бөгөөд операторуудын сургалт, хээрийн хуулалтын ажил ойрын хугацаанд эхэлнэ.

Нөөцийн шинэчилсэн тооцоо, өрөмдлөгийн үр дүн дээр үндэслэн 2025 оны 2-р хагас болон түүнээс цааших олборлолтын цар хүрээг нэмэгдүүлэхээр судалж байна.

### ТОП-20 ИНДЕКСИЙН ГҮЙЦЭТГЭЛ 4-Р САРААС ХОЙШ СЭРГЭЛЭЭ

2025 оны эхний дөрвөн сарын байдлаар үнэт цаасны зах зээлд нийт 260.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 25.8 тэрбум төгрөгөөр (11.0%) өссөн үзүүлэлт болж байна. Үүнээс анхдагч зах зээлийн арилжаа 68.0 тэрбум төгрөгөөр (26.2%), хоёрдогч зах зээлийн арилжаа 192.0 тэрбум төгрөгөөр (73.8%) тус тус бүрдүүлжээ.

График 3. ТОП-20 индекс (оны эхнээс)



Нийт гүйлгээний бүтцийг авч үзвэл:

- 41.5 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас,
- 26.8 хувийг компанийн бонд,
- 23.9 хувийг компанийн хувьцаа,
- 7.4 хувийг Засгийн газрын бонд,
- 0.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх тус тус эзэлж байна.

Түүнчлэн, зөвхөн 2025 оны 4 дүгээр сард үнэт цаасны арилжаа 87.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 41.2 тэрбум төгрөгөөр (89.0%), өмнөх сараас 23.0 тэрбум төгрөгөөр (35.6%) тус тус өссөн нь зах зээл идэвхжиж буйг илтгэж байна.




## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.